



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

“Геологийн судалгаа-шинжилгээний төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл
бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Д.Мөнхбаатартай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал Д.Мөнхбаатартай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул Захирал Д.Мөнхбаатарт хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Захирал Д.Мөнхбаатарт хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч Ш.Амарзаяад зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132061355
14-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
220 дугаар тогтоолын хавсралт

"ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛД
2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг /төг/	Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал /мян.төг/	Урамшуулал тооцох цэвэр ашиг /мян.төг/	Олгох урамшууллын хэмжээ /төг/
1	"Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ	Д.Мөнхбаатар	552,560,167.41	0.0	552,560,167.41	20,525,601.67 (Хорин сая, таван зуун хорин таван мянга, зургаан зуун нэг төгрөг)